

11.1 Шалгалтын дүн системд оруулах дараалал

Улсын шалгалтын дүнгийн мэдээллийг системд дараах дарааллыг баримтлан оруулна.

1. Сургалтын менежерийн эрхээр улсын шалгалтанд шалгуулагч бүртгэх, дүн бүртгэх болон дүн илгээх боломж бүхий шалгалт эрхийг тухайн төгсөх ангийн **анги удирдсан багш** нарт (es37..-той шалгалтын эрх) хуваарилж өгнө.

2. Ангид удирдсан багш нь шинээр хуваарилагдсан ES37***** -той шалгалтын эрхээр нэвтэрч **зөвхөн хариуцсан ангийн** суралцагчийг шалгалтанд бүртгэх боломжтой. Хэрэв тухайн шалгалтанд орох ёсгүй суралцагчийг бүртгэсэн бол шалгалт өгөгч хасах үйлдлээр хасна.

3. Ангид удирдсан багш нь зөвхөн хариуцсан анги бүлгийн суралцагчдийн улсын **шалгалтын ирц** болон **шалгалтын дүнг** оруулж хадгална.

4. Ангид удирдсан багш нь шалгалт өгсөн анги бүлгийн суралцагч нэг бүрийн шалгалтын дүнг бүрэн оруулсны дараа харъяа БСУГ -т баталгаажуулах хүсэлт илгээх үйлдлийг хийнэ.

5. Улсын шалгалттай холбоотой гарын авлагууд

Гарын авлага - [Сургалтын менежер](#)

Гарын авлага - [Улсын шалгалтын эрх](#)

Анхаарах зүйлс:

Улсын шалгалтын дууссан хугацаанаас 30 минут (задгай даалгаварыг засах хугацаа)-ын дараа системд тухайн улсын шалгалтын дүнг суралцагч нэг бүрээр шивж оруулах бөгөөд системд шивж оруулсан цагаас 24 цагийн турш шалгалтын дүнг оруулах боломжтой байна.

11.2 Системийн эрхийн тухай

Системийн эрхийн тухай

Сургуулийн захирлын эрх болон сургалтын менежерийн эрх (es33.. эсвэл es32..) нь сургуулийн хамгийн том эрх бөгөөд өөрийн эрхийн хүрээнд үйлдлүүдийг хийх, эрх хуваарилах, хуваарилагдсан эрхүүдэд хийгдсэн үйлдлийг хянах, баталгаажуулах гэх мэт үйлдлийг ханган ажиллана.

Улсын шалгалтад захирлын эрх (es33.. эсвэл es32..) нь улсын шалгалтын комиссуудад улсын шалгалтын эрх (es37..) хуваарилж өгөх үүргийг гүйцэтгэн ажиллана.

Улсын шалгалтын үед эрхүүд дараах үйлдлийг хийж ажиллана.

Системийн эрх

Захирлын эрх (es33.. эсвэл es32..)

Хийх үйлдэл

Сургуулийн улсын шалгалт өгсөн суралцагчийн ирц, шалгалтын дүнг харах

Шалгалтын эрх (es37..)

Улсын шалгалтын комиссын гишүүдийг томилох
Улсын шалгалтын комиссын томилогдсон гишүүдээс
улсын шалгалт өгсөн анги бүлгийн системд дүн
оруулах, хянах болон шалгалтын материал хянаж
зассан комиссын гишүүн нь хэн болохыг оноох
Улсын шалгалтад орох анги бүлгийн суралцагчийг
бүртгэх

Улсын шалгалт өгсөн анги бүлгийн суралцагч бүрийн
ирц бүртгэж, шалгалтын материалыг даалгавар
бүрээр оруулж хадгална.

Улсын шалгалт өгсөн анги бүлгийн суралцагчийн
дүнг бүрэн оруулж хадгалсны дараа шалгалтын
дүнг баталгаажуулах үйлдэл хийнэ.